

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



“АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН
БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439,

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225

Ахлах аудитор Т.Батсайхан
Аудитор Б.Гантуяа
Утас: 7059-2208,
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	2
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3-4
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.</u>	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1.1 Аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.	5
Ахлах аудитор Т.Батсайхан	1.1.2 Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоосон нотлох баримт хангалтгүй байна.	6
Аудитор Б.Гантуяа	1.1.3 Төслийг сонгон шалгаруулахдаа түүнийг хэрэгжүүлэгч иргэнээр хамгаалуулдаг болсон байна.	6-7
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	1.1.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	7
ХАЯГ:	1.1.5 Зээлийн эргэн төлөлт хэвийн болж сайжирсан байна.	7-8
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	1.1.6 Хяналт шалгалтыг төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж ажиллаагүй байна.	8
2023 оны 10 дугаар сар	1.1.7 Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулсан байна.	8-9
	1.1.8 Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна .	9
	1.2 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.	9
	1.1.1 Албан шаардлагын хүрээнд 68.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.	9
	1.1.2 Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	10
	1.3 Үндэсний аудитын газраас дамжуулан холбогдох яамдад хүргүүлсэн 3 саналаас 2 санал нэгдсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжид дурдагдсан байна.	10
	Дүгнэлт	11

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ХШҮ	Хяналт, шинжилгээ үнэлгээ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн үнэлгээг харьцуулан	5
Хүснэгт 2	Шинэчлэн батлуулсан арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Хяналт, үнэлгээ шинжилгээ дотоод аудитын хэлтсээс 2023 оны хагас жилийн байдлаар үнэлсэн үнэлгээ	5
Хүснэгт 3	Төсөл хөтөлбөрөөр олгогдсон санхүүжилтийн судалгаа	6

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Хяналт шалгалт хийх
үндэслэл, бүрэн эрх:*

Аудитыг МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.3, МУЕА-ын 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу өөрийн санаачилгаар хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд **“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”**-нд хийсэн аудитын үр дүнд өгсөн албан шаардлага, зөвлөмж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн саналын хэрэгжилтийг ирүүлсэн хариу тайлбар, нотлох баримттай газар дээр нь тулган шалгах, үр дүнг тооцож зорилтын биелэлтийг хангах, аудитын үр дүнг тайлагнахад чиглэнэ.

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Хяналт шалгалтад илрүүлэлтийн хүснэгтэд тусгасан асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах стандарт, хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ❖ АДБОУС
- ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020
- ❖ МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам
- ❖ МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан ГА-ын заавар, аргачлал /5.8/

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Дундговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар бусад холбогдох байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулсан.

Шалгалтыг аудитын матрицад тусгасан асуулт, арга зүй, нотлох баримт цуглуулах аргуудын хүрээнд хийж, нөхцөл байдал, үр дүнг аудитын илрүүлэлтийн хүснэгтээр баримтжуулсан.

Аудитын арга зүй:

Шалгалтыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, шалгалтын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа нар 2023 оны 10 дугаар сарын 05-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.



БҮЛЭГ 1. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.1 АУДИТААР ӨГӨГДСӨН 11 ЗААЛТ ЗӨВЛӨМЖ ӨГСНӨӨС 5 ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИЖ, ХЭРЭГЖИЛТ 45.5 ХУВЬТАЙ БАЙНА.

1.1.1 Аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.



“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Дундговь аймгийн Засаг даргад 2 зөвлөмжийн хүргүүлж ажилласан байна.

Тус зөвлөмжийн хүрээнд Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөснөөс 2 арга хэмжээг, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөж 1 арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж, 2022 онд шинэчлэн батлуулсан байна. Дээрх 3 арга хэмжээг 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн үнэлгээг харьцуулан харуулбал:

Хүснэгт №1

Арга хэмжээ	Үнэлгээ	ЗГХЭГ үнэлгээ
2.4.2.1. Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байранд зуучилж, бүртгэлжүүлэн, ажлын байртай болгох	100	70
2.4.2.2. 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	100	50
2.4.2.3. Түр ажлын байранд иргэдийг зуучилж ажлын байртай болгох	100	100

Хүснэгтээс харахад аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжсэн гэж үнэлсэн байхад Засгийн газрын хэрэг эрхлэх газрын үнэлгээгээр дунджаар 73.3 хувьтай байгаа нь хэрэгжилтийг үнэлгээ харилцан адилгүй байгааг харуулж байна.

Шинэчлэн батлуулсан арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2023 оны хагас жилийн байдлаар үнэлсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

Арга хэмжээ	Үнэлгээ /ХШҮ хийлгэсэн үнэлгээ/
Арга хэмжээ: Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байранд зуучилж, бүртгэлжүүлэн, ажлын байртай болгох	50
Арга хэмжээ: 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	30
Арга хэмжээ: Түр ажлын байранд иргэдийг зуучилж ажлын байртай болгох	10

Хагас жилийн байдлаар тус арга хэмжээнүүдийн үнэлгээ дунджаар 30 хувьтай үнэлэгдсэн байна. Арга хэмжээний үнэлгээ бага байгаа талаар тодруулахад 2023 оны хагас жилд Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй буюу дуусаагүй байсан тул хэрэгжилт бага хувьтай гарсан гэсэн тайлбарыг өгч байна. Иймд дээрх арга хэмжээнүүдийг жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

1.1.2 Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоосон нотлох баримт хангалтгүй байна.



Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тоон мэдээлэлд тулгуурлан тооцоо судалгааг нарийвчлан хийдэггүй, аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллээр тоон мэдээллийг боловсруулан гаргаж байгаа нь өөрийн байгууллагын хэмжээнд бодитой тооцоо судалгаа байхгүйг харуулж байна. Иймд 2018 онд хийгдсэн Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн судалгаан дээр үндэслэн судалгаа шинжилгээг нарийвчлан хийж, тоон мэдээлэлд тулгуурлан зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоон төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулж байх шаардлагатай байна.

1.1.3 Төслийг сонгон шалгаруулахдаа хэрэгжүүлэгч иргэнээр хамгаалуулдаг болсон байна.



Төслийг сонгон шалгаруулахдаа төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага, зах зээлийн багтаамж, эдийн засгийн тооцоолол, санхүүжилтийн зарцуулалт, хүрэх үр дүн, ажил хөдөлмөр эрхэлдэг эсэх, зээлийн мэдээлэл, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан эсэхэд үндэслэн иргэн өөрөө төслөө хамгаалдаг нь зээлийн эргэн төлөлт болон төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжих боломжтой үр дүнтэй ажил болсон байна.

Төсөл хөтөлбөрөөр олгогдсон санхүүжилтийн судалгаа:

Хүснэгт.№3

№	Сумдын нэр	Хүн амын тоо	Ажилгүй иргэдийн тоо	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо		
				2022 он хүний тоо	Олгосон санхүүжилт	Ажилгүй иргэдийн тоонд харьцуулсан хувь
1	Адаацаг	2746	23	3	25.0	13.0
2	Баянжаргалан	1290	22	4	33.0	18.2
3	Говь-Угтаал	1458	20	9	73.0	45.0
4	Гурвансайхан	2124	85	7	50.0	8.2
5	Дэлгэрхангай	2225	36	7	45.0	19.4
6	Дэлгэрцогт	1573	26	1	5.0	3.8
7	Дэрэн	2138	15	4	25.0	26.7
8	Луус	1865	60	4	25.0	6.7
9	Өлзийт	2274	103	2	17.0	1.9
10	Өндөршил	1434	38	3	20.0	7.9
11	Сайнцагаан	16792	828	44	318.0	5.3
12	Сайхан-Овоо	2131	87	4	20.0	4.6
13	Хулд	2305	80	4	25.0	5.0
14	Цагаандэлгэр	995	21	1	5.0	4.8
15	Эрдэнэдалай	5849	99	12	80.0	12.1
Нийт дүн		47199	1543	109	766.0	7.1

Эх сурвалж: ХХҮГ

Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоог ажилгүй иргэдийн тоонд харьцуулсан хувиас харахад харилцан адигүй байгаа нь бүс нутгийн онцлог шинж чанар, хүн ам, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үзүүлэлтийг харгалзан хуваарилаагүй байна. Энэ нь өрхийн бизнес эрхлэх сонирхолтой иргэд цөөн, орон нутгаас төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийн оролцоо багатай, цалингийн болон бусад зээл өндөртэй байдаг учраас шалгуур үзүүлэлт хангадаггүй байна.

1.1.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал:

1. Гэрэлтдэг ертөнц төрийн бус байгууллага, Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Нарру том эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шалгарсан 12 эмэгтэйд тус бүр ментор холбон ажиллуулснаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, өөртөө итгэх итгэл олгох харилцан ярилцах, өөрсдийн ажил мэргэжил, эрхэлдэг ажилтай танилцуулж амьдралын зөв хэвшил дадал хэвшилд сургахад анхаарч ажилласан.
2. Орон нутгийн түвшинд амжилттай ажиллаж, бусдад эерэг нөлөө үзүүлдэг, хувь хүний хөгжлөөрөө бусдыгаа манлайлж байгаа 50 залуусыг тодруулснаар хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудыг бие биетэйгээ танилцаж бизнесийн түншээ олж авах болон хамтран ажиллах боломжоор хангасан байна.

Мөн хөтөлбөрт хамрагдсан залуучууд хамтран Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр “Эрсдэлгүй Сайнцагаан”, “Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт”, “Та бусдад юу түгээдэг вэ?” нөлөөллийн аянуудыг зохион байгуулсан байна.

И-жоб программ 2023 оны 1 дүгээр сараас ашиглалтад орж профайлингийн үнэлгээ хийснээр ажилгүй иргэдийн тоон мэдээлэлд тулгуурлан ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдэд дүгнэлт хийх, сургалтад хамруулах үйлчилгээ сайжирч үүний үр дүнд 667 иргэнийг ажилд зуучилсан байна. Үүнээс байнгын 277, түр ажлын 358 иргэн, цагийн ажил болон улирлын чанартай ажлын байранд 32 иргэнийг ажлын байраар хангаж, давхардсан тоогоор 108 иргэн профайлинг үнэлгээнд хамруулсан байна. Мөн иргэд болон аж ахуйн нэгж байгууллага И-жоб программд ажлын зар мэдээ оруулах, ажлын байр хайх өөрийн анкетыг сонирхсон ажлын байр зарлагдсан байгууллагад илгээх, иргэдийн анкет мэдээг шүүж үзэх зэрэг ажлууд хийгдэж байна. И-жоб программ нь Улсын бүртгэлийн “Хур” системтэй холбогдсоноор Нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагааг авч, ажилгүй иргэдийг төсөлд хамруулахад ашиглах нэг шалгуур үзүүлэлтийг хялбаршуулсан байна.

1.1.5 Зээлийн эргэн төлөлт хэвийн болж сайжирсан байна.



Төсөл хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн үйл ажиллагаанд сум хариуцсан мэргэжилтнүүд анхан шатны хяналт хийж хяналтын хуудсаар баталгаажуулж санхүүжилт олгосны дараа байгууллагын дотоод хяналтаас үр дүнгийн хяналт хийн ажиллаж байна.

Санхүүгийн анхан шатны мэдлэг олгох, Бизнесээ эхлэх хөгжүүлэх чиглэлээр аж ахуй эрхлэлтийн сургалт болон дараах ажлуудыг зохион байгуулсан байна.

1. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын тушаалаар авлага барагдуулах ажлын хэсэг байгуулж, зээлийн эргэн төлөлтийг сар бүр төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнаж байна.
2. Зээлийг хугацаандаа төлөөгүй иргэдтэй биечлэн уулзаж мэдэгдэх хуудас өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдэд зээлээ хугацаандаа төлөх сануулга масс мессежийг туршилтаар хийхээр ажиллаж байна. Ингэснээр зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэлтийг 53.3 хувиар бууруулсан байна.

1.1.6 Хяналт шалгалтыг төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж ажиллаагүй байна.



Төсөл хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн үйл ажиллагаанд сум хариуцсан мэргэжилтнүүд анхан шатны хяналт хийж хяналтын хуудсаар баталгаажуулан ирүүлснээр буюу санхүүжилт олгосны дараа байгууллагын дотоод хяналтаас үр дүнгийн хяналт хийн ажиллаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа хяналтын хэлтсээс төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн удаашралтай байгаа заалтууддаа үр дүнг тооцон ажиллаж байгаа гэсэн хэдий ч төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж ажиллаагүй зөвхөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдэд хяналт хийж тайлагнасан байна. Хяналт шалгалтын тайлангаар илэрсэн зөрчил, түүнийг арилгах талаар өгсөн зөвлөмж, цаашид ямар арга хэмжээг зохион байгуулж шийдвэрлэх талаар дурдаагүй байна. Энэ нь хяналт шалгалт үр дүнгүй болох үр дагаварыг бий болгож байна. Иймд хяналт шалгалтыг төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулсан үр дүнг тооцож ажиллах шаадлагатай байна.

1.1.7 Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулсан байна.



Дундговь аймгийн хэмжээнд Профайлинг үнэлгээний нэгдсэн дүгнэлтээр А¹ үнэлгээтэй 60 иргэн, В² үнэлгээтэй 147 иргэн, С³ үнэлгээтэй 185 иргэн, Д⁴ үнэлгээтэй 90 иргэн дүгнэгдсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас батлагдсан сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран С, Д үнэлэгдсэн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, мөн богино хугацааны ур чадвар олгох, мэргэжлийн сургалтад хамруулж худалдагч, касс 30, уурын зуухны машинист 43, харуул хамгаалалтын ажилтан 29, гар урлал 12 нийт 114 иргэнд мэргэжлийн үнэмлэх олгосон байна.

Харин В үнэлэгдсэн хувиараа бизнес эрхлэгч иргэнд санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах, иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөх үйлчилгээнд хамруулсан байна. Мөн Хөдөлмөрийн зах зээлийн EJob программд бүртгэлтэй ажилгүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн иргэдийг Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний суурь ур чадварын сургалтад хамруулж ажилд зуучилж байна.

Хамт олны дунд удаан ажиллаагүй, өөртөө итгэх итгэл нь буурсан, сэтгэл зүйн хувьд зайлшгүй дэмжлэг хэрэгтэй байгаа ээжүүдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан “Нарру том” эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрт хамрагдсан 12 эмэгтэйд профайлинг үнэлгээ хийж, хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудалд

¹ А - хөдөлмөр эрхлэх бүрэн боломжтой иргэн,

² В - "Ажилд зуучлахын тулд богино хугацааны дэмжих үйлчилгээ шаардлагатай иргэн" гэж үзэх бөгөөд иргэний онцлогоос хамаарч хөдөлмөрийн зах зээлээс 31-180 хоног хүртэлх хугацаагаар алслагдсан байдаг. Энэ бүлгийн иргэд ихэвчлэн бичиг баримтын бүрэн байдал, ажил хайх сүлжээ, ажилласан туршлага нь хязгаарлагдмал байдаг. "Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө"-нд үйлчилгээний залгамж холбоо, үр дүнг алдахгүй байхаар тусгах шаардлагатай. Жишээлбэл: Хөдөлмөрт бэлтгэх, Дадлагажих хөтөлбөр, Ажилд зуучлах үйлчилгээ гэх мэт

³ С- "Ажилд зуучлахын тулд урт хугацааны дэмжих үйлчилгээ шаардлагатай иргэн" гэж үзэх бөгөөд иргэний онцлогоос хамаарч хөдөлмөрийн зах зээлээс 181-365 хоногийн хугацаагаар алслагдсан байдаг. Энэ бүлгийн иргэд ихэнхдээ хөдөлмөр эрхлэх сэдэл, боловсрол, мэргэжил, ажлын туршлага, дасан зохицох чадвар нь хязгаарлагдмал байдаг. Иймд иргэний "Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө"-нд үйлчилгээний залгамж холбоо, үр дүнг алдагдуулахгүй байхаар тусгах шаардлагатай. Жишээлбэл: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, Мэргэжлийн сургалт, Дадлагажуулах хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх сургалт, Ажилд зуучлах үйлчилгээ

⁴ Д- "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд ажил эрхлэхтэй холбоотой асуудлуудыг нь шийдвэрлэх боломжгүй бөгөөд холбон зуучлах шаардлагатай иргэн

үндэслэн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөх болон сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж, 21 хоногийн хугацаанд оролцогчдод дараах ур чадварыг олгосон байна. Үүнд:

- Хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар дээшлүүлэх сургалт
- Мэргэшүүлэх, ур чадвар нэмэгдүүлэх сургалт,
- Цахим ур чадвар эзэмшүүлэх сургалт,
- Инээмсэглээрэй хөдөлгөөнт дасгал

Тус хөтөлбөрийн үр дүнд 7 эмэгтэй ажлын байранд зуучлагдаж, 1 эмэгтэй хувиараа бизнес эрхэлж, 2 эмэгтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Старт-Ап” арга хэмжээнд оролцсон байна.

1.1.8 Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл төлөвлөгөө боловсруулан ажилаж байна .



Аймгийн Хөдөлмөр эрхлэх зөвлөл нь ***“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д*** хийсэн гүйцэтгэлийн аудитаас өмнөх хугацаанд дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлого төлөвлөлтгүй явж ирсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл төлөвлөгөө боловсруулан 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус арга хэмжээнүүдийн хэрэгжилт 87 хувьтай байна. Тус зөвлөл нь төлөвлөгөөндөө хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллагуудыг хэрхэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар тусгаагүй байна.

1.2 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

1.2.1 Албан шаардлагын хүрээнд 68.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Тус албан шаардлагыг хэрэгжүүлж 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг 2022 онд Хаан банкнаас 16.8 сая төгрөг, Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ Төрийн өмчит хувьцаат компаниас 15.1 сая төгрөг нийт 31.9 сая төгрөгийг, 2023 онд Хаан банк 16.1 сая төгрөг, Монгол алт хязгаарлагдмал хариуцлагатай компаниас 19.8 сая төгрөг, Мэйжик бридж 0.5 сая төгрөг нийт 36.4 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тус тус төвлөрүүлсэн байна. Хөдөлмөрийн хяналтын улсийн байцаагч нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт чиг үүргийн дагуу шилжиж ирснээр Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйлийн хэрэгжилтийг хангуулж ажиллахад үр дүнгээ өгсөн байна.

1.2.2 Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.



Аудитаар өгсөн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд тавигдсан төлбөрийн актын авлагыг барагдуулах зорилгоор ажлын хэсгийн байгуулан ажилласнаар 153.5 сая төгрөгийн үлдэгдэл авлагаас 81.7 сая төгрөг буюу 53.3 хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн. Зээлийн авлагын үлдэгдэл барагдуулаагүй нийт 71.6 сая төгрөгөөс төлөлтийг тохиролцсон хугацаандаа хийгээгүй 69.5 сая төгрөгийг үлдэгдэлтэй

17 иргэнийг иргэний хэргийн анхан шатны шүүх рүү шилжүүлж, эзэн холбогдогч нь сураггүй алга болсон иргэний хэргийн анхан шатны шүүхээс хүлээн авахаас татгалзсан 1 иргэний 0.5 сая төгрөгийн найдваргүй авлага барагдуулах хүсэлтийг Хөдөлмөр, халамжийн ерөнхий газарт албан бичгээр хүргүүлж, 4 иргэний 1.6 сая төгрөгийг 2023 ондоо багтаан төвлөрүүлэхээр иргэдтэй тохиролцсон байна.

Сумдаас ирүүлсэн төсөлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээр төслөө хамгаалуулдаг болсноор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу зарцуулж, зээлийн эргэн төлөлт хэвийн болсон байна.

1.3 Үндэсний аудитын газраас дамжуулан холбогдох яамдад хүргүүлсэн 3 саналаас 2 санал нэгдсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжид орсон байна.

Үндэсний аудитын газраар дамжуулан холбогдох яамдад хүргүүлсэн саналуудаас 2 санал нэгдсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн хэсэгт дурдагдсан байна. Тухайлбал:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр хариуцсан албан хаагчид хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагаас авах, шаардлага тавих, түүнийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг эрхтэй байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах шаардлагатай талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх санал хүргүүлснийг нэгдсэн тайлангийн Нийгмийн хамгааллын сайдад өгсөн зөвлөмж⁵ №2-д оруулсан;
2. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системийн алдаа, дутагдлыг арилгах, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх саналыг нэгдсэн тайлангийн дүгнэлт⁶ хэсэгт тусгасан байна.

Харин хугацаа хэтэрсэн зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны чанаргүй зээлийн мэдээллийн санд оруулдаг болох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх санал тусгагдаагүй байна. Саналыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлдэг ч Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас дэмжлэг олгож байгаа тул зээл биш гэдэг тайлбарыг өгдөг бөгөөд одоогоор албан бичгээр хариу ирүүлээгүй байна.

⁵...эрх зүй орчныг сайжруулах

⁶ ... мэдээллийн сангийн үйл ажиллагаа хангалтгүй, системийн ажиллагаа бүрэн бус байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг 1. *“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар 8 заалт зөвлөмж өгсөнөөс 4 зөвлөмжийн хэрэгжилт 30-87 хувьтай, 4 зөвлөмж бүрэн хэрэгжиж, хэрэгжилт 70.6 хувьтай байна.*

- 1. Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг мөрдөөгүй, хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарим шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хангаагүй, хөдөлмөр эрхлэлт хариуцсан төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаагүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой судалгаанд үндэслэн тооцоолоогүй, иргэд, олон нийтийн оролцоог хангахгүй байна. Үүнтэй холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүд бүрэн хэрэгжихгүй, үр дүнд чиглэхгүй байна.*
- 2. И-жоб программ 2023 оны 1 дүгээр сараас ашиглалтад орж профайлингийн үнэлгээ хийснээр ажилгүй иргэдийн тоон мэдээлэлд тулгуурлан ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдэд дүгнэлт хийх, сургалтад хамруулах үйлчилгээ сайжирч үүний үр дүнд 667 иргэнийг ажилд зуучилсан байна.*
- 3. Хугацаа хэтэрсэн 153.5 сая төгрөгийн үлдэгдэл авлагаас 81.7 сая төгрөг буюу 53.3 хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн байна.*
- 4. Үндэсний аудитын газраас дамжуулан холбогдох яамдад хүргүүлсэн 3 саналаас 2 санал нэгдсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжид орсон байна.*

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН